



**МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН  
МЕНЕЖМЕНТИЙН БОДЛОГО**

# МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН БОДЛОГО

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн бодлого нь технологи ашигласан зээлийн үйл ажиллагаа, санхүүгийн үйлчилгээ, хэрэглэгч, хамтран ажиллах байгууллагын мэдээллийн нууцлал, хүртээмжтэй байдал, бүрэн байдлыг хангах зорилгоор ISO27001 стандартын дагуу Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, хянах, тасралтгүй сайжруулахаар зорьж ажиллана.

Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо нь дараах бодлогыг баримтална. Үүнд:

## 1. Мэдээллийн нууцлалыг хамгаалах:

Мэдээллийн хөрөнгө нь компанийн өмч бөгөөд түүний бүрэн бүтэн байдал болон нууцлалыг чанд хамгаална.

## 2. Хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын шаардлагыг хангах:

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Монгол улсын хууль, Зохицуулагч байгууллагын мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой дүрэм, журам, стандартын шаардлагад нийцсэн байна.

## 3. Бизнесийн тасралтгүй байдлыг хангах:

Компанийн үнэт цаас эзэмшигч, үйлчилгээ үзүүлэгч, харилцагч байгууллагууд болон харилцагчийн мэдээллийн аюулгүй байдлын хангах нөхцөлийг бүрдүүлж бизнесийн үйл ажиллагааны тогтвортой тасралтгүй байдлыг хангахад чиглэнэ. Мэдээллийн аюулгүй байдал (МАБ)-ын менежментийн бодлого нь компанийн стратегийн чиглэлд нийцүүлсэн мэдээлэл технологийн бодлого болон мэдээллийн аюулгүй байдлын зорилтуудыг тодорхойлох зарчмыг баримтална.

**4. Бизнесийн харилцаа:** МАБ-ын менежментийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэгч байгууллага, үүрэн холбоо, банк, төсөл хэрэгжүүлэгч гэх мэт төрийн болон хувийн байгууллагуудтай гэрээ байгуулж хамтарч ажиллахдаа Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO27001 стандартын шаардлагыг хангахуйц байхыг зорино.

**5. МАБ-ын эрсдэлийн удирдлага:** МАБ-ын эрсдэлийн төрөл, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүлээн зөвшөөрөх хязгаар, тэдгээрийн эзэд/хариуцагч/-ийг тодорхойлохдоо “Эрсдэлийн удирдлагын бодлого”-д заасны дагуу удирдаж, тодорхойлно.